Нийт зардал өмнөх оноос 3,143,093.1 мянган төгрөгөөр буюу 3.6 дахин өсчээ. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил 45,409.1 мянган, ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8,428.6 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,013.9 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 12,274.5 мянган, урсгал шилжүүлэг 3,286,637.2 мянган төгрөгөөр тус тус өсч, хангамж, бараа материалын зардал 39,426.5 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 12,863.1 мянган, томилолтын зардал 9,972.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 152,408.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд дараах нэр төрлийн зардлыг санхүүжүүлэхээр нийт 5,571,975.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, саналыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Үүнд:

- Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,535,709.5 мянган төгрөг;
- Азийн Хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний Хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээ хөгжлийн нэгдсэн төв, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Архангай, Хөвсгөл болон Ховд аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн жишиг 6 төвийг байгуулах эх үүсвэрийг улсын төсвөөс 4,036,266.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэх;

Тайлант оны төсвийн төслийн саналаас нийт 4,249,432.9 мянган төгрөгөөр буюу 1,322,542.7 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Үүнд:

- Өөрийн үндсэн үйл ажиллагааны зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 97,095.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэл 20,636.7

мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 110,025.1 мянган, хангамж, бараа материалын зардал 18,592.4 мянган, эд хогшил худалдан авах зардал 1,554.4 мянган, томилолт зочны зардал 24,192.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 282,464.2 мянган, урсгал шилжүүлэг 25,000.0 мянган, нийт 579,559.8 мянган төгрөгөөр бууруулж;

- Нийт 6 аймгийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн зардлаас 742,982.9 мянган төгрөгөөр бууруулж тус тус баталсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 956,149.7 мянган, 6 аймгийн төслийн зардлыг санхүүжүүлэхээр 3,244,848.2 мянган, үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 48,435.0 мянган, нийт 4,249,432.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр тус төвийн өөрийн үндсэн үйл ажиллагаанд улсын төсвөөс 956,149.7 мянган, 6 аймгийн төслийн үйл ажиллагаанд 3,244,848.2 мянган, нийт 4,200,997.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 48,435.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 12,000.0 мянган төгрөгийг бүрдүүлж, үндсэн үйл ажиллагаанд 895,276.7 мянган төгрөгийг зарцуулж, 3,317,723.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21.1 хувьтай байгаа нь 6 аймгийн төслийн үйл ажиллагааны санхүүжилтыг зарцуулалгүй 100.0 хувь буцаан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Тус төвийн үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 895,276.7 мянган төгрөг буюу 93.6 хувийг зарцуулсан байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 30,260.9 мянган, байр ашиглалтын зардлыг 10,694.3 мянган, хангамж, бараа материалын зардлыг 1,819.1 мянган, эд хогшил худалдан авах зардлыг 459.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 24,139.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, томилолтын зардлыг 6,500.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	72206-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал	4,249,432.9	895,274.7	(3,354,158.2)	21.1
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	4,200,997.9	895,274.7	(3,305,723.2)	21.3
1.2	Хөрөнгийн зардал	48,435.0		(48,435.0)	(100)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,849.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа материалын зардалд 1,389.0 мянган төгрөгийг зарцуулж, 7,460.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлт, үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Энхтуул, аудитор М.Мөнхзул нар гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Их наяд Аудит" ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,910,780.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 39,107.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд зарцуулсан бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,076.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тус байгууллага нь дэд, орлогч даргын 2 орон тоог хасаж, нэг удаагийн тэтгэвэр тэтгэмж олгоогүй, суурин утасны төлбөрөөс өөр төрлийн утасны зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 12 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 145 мэдээлэл байршуулахаас 101,274,100.00 төгрөгийн орлогын 2 гүйлгээ дутуу, 21,218,000.00 төгрөгийн зарлагын 3 гүйлгээ дутуу, худалдан авалтын 7,218,000.00 төгрөгийн 1 гүйлгээ дутуу байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 70,152.2 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илрүүлснээс 31,893.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 38,259.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг хэрэгжүүлээгүй тул тайлант оны зөрчилд оруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1,144.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 7,309.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг 100.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,144.0	1	1,144.0	100.0
Зөвлөмж	1	7,309.8	1	7,309.8	100.0
Нийт дүн	2	8,453.8	2	8,453.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх оны аудитаар дурьдсан ЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Дэл оюу дөл ХХК-д протезийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүжилтийн эргэн төлөлт тайлант онд хийгдээгүй тул дараагийн аудитаар дахин анхаарч авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,625.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Бараа материалын тайланд 72.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн, шаардах хуудасгүй 35.7 мянган төгрөгийн бараа материал зарлагадсан зэрэг нийт 108.3 мянган төгрөгийн алдааг залруулж бүртгэн баримтжуулсан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 356 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэхдээ 74,051.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө шилжүүлэх байсныг 66,885.0 мянган төгрөгөөр шилжүүлж 7,166.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулж бүртгэсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тендерийн 11,800.0 мянган төгрөгийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэл тайланд тусгаагүй байсныг залруулж бүртгэсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 9,734.4 мянган төгрөгөөр илүү, ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлыг 8,359.9 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулж бүртгэсэн.
- Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг журналд 8,136.2 мянган төгрөгөөр илүү тусгасныг залруулж бүртгэсэн.
- Мөнгөн хөрөнгийн журналаас зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 53,040.3 мянган төгрөгийн и-баримтын бүрдэл дутуу байсныг залруулж бүртгэсэн.

Аудитаар нийт 33,489.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,490.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,076.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 23,922.7 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 33,489.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдал түвшин 39,107.8 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд албан томилолтын ажлын тайлан болон анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6,490,000.00 (зургаан сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Тайлант онд зарцуулсан бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,076,800.00 (гурван сая далан зургаан мянга найман зуу) төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн журналаас зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 14,791.2 мянган төгрөгийн и-баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И-баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 9,131.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайланд бичиг хэргийн 72.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн, шаардах хуудасгүй 35.7 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан байна.	2	108.3			2	108.3	2	108.3				
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 356 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэхдээ 74,051.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө шилжүүлэх байсныг 66,885.0 мянган төгрөгөөр шилжүүлсэн байна.	1	7,166.3			1	7,166.3	1	7,166.3				
Санхүүгийн үр дүнгийн тайланд тендерийн 11,800.0 мянган төгрөгийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэл тайланд тусгаагүй.	1	11,800.0	1	11,800.0			1	11,800.0				
Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 9,734.4 мянган төгрөгөөр илүү, ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлыг 8,359.9 мянган төгрөгөөр дутуу, зөрүү 1,374.5 мянган төгрөгөөр илүү тусгасан.	2	1,374.5			2	1,374.5	2	1,374.5				
Цалингийн хүснэгтээрх ажилтанаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг журналд илүү тусгасан.	1	8,136.2			1	8,136.2	1	8,136.2				
Мөнгөн хөрөнгийн журналаас зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад	1	53,040.3			1	53,040.3	1	53,040.3				

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

53,040.3 мянган төгрөгийн и-баримтын бүрдэл дутуу байна.												
Дүн	8	81,625.6	1	11,800.0	7	69,825.6	8	81,625.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн журналаас зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 14,791.2 мянган төгрөгийн и-баримтын бүрдэл дутуу байна.	1	14,791.2					1	14,791.2				
Тайлант онд зарцуулсан бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,076.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан.	1	3,076.8			1	3,076.8						
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 9,131.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн	1	9,131.5					1	9,131.5				

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.												
Тайлант онд албан томилолтын ажлын тайлан болон анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6,490.0 төгрөгийг зарцуулсан байна.	1	6,490.0	1	6,490.0								
Дүн	4	33,489.5	1	6,490.0	1	3,076.8	2	23,922.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 101,274.1 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ дутуу, 21,218.0 мянган төгрөгийн зарлагын 3 гүйлгээ дутуу, худалдан авалтын 7,218.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ дутуу байршуулсан байна.	1	129,710.1			1	129,710.1		
Дүн	1	129,710.1			1	129,710.1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023

02

24

№ 116/АД/50458

Улаанбаатар хот

СНАГ-2023/310/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зарцуулсан бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3,076,800.00 (гурван сая далан зургаан мянга найман зуу) төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Нямсүрэн, нягтлан бодогч Б.Баасандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Үндэсний дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264330

Э. Албан шаардлага 2023.02.24 СНАГ-18.1000

0001080178



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 04 № 115/А0150458

Улаанбаатар хот

СНАФ-2023/310/НА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн-бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 145 мэдээлэл байршуулахаас 101,274,100.00 төгрөгийн орлогын 2 гүйлгээ дутуу, 21,218,000.00 төгрөгийн зарлагын 3 гүйлгээ дутуу, худалдан авалтын 7,218,000.00 төгрөгийн 1 гүйлгээ дутуу байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын захирал Ц.Нямсүрэн, нягтлан бодогч Б.Баасандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023

02

дугаар сарын 04

№ 20/ А0150458

Улаанбаатар хот

СНАГ-2023/310/НА-СТА-ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд албан томилолтын ажлын тайлан болон анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6,490,000.00 (зургаан сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан 6,490,000.00 (зургаан сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 дугаартай дансанд төслөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Нямсүрэн, нягтлан бодогч Б.Баасандолгор нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 7-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264250

Х.А. 2023.02.04 06:03:19.000

0001000534

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ӨӨРЧЛӨЛТГҮЙ